

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл ба арга зүй

Эрүүл мэндийн байгууллагын 2025 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д нийцүүлэн гүйцэтгэл, үр дүн, чанар, ил тод байдал, хэрэглэгчийн үнэлгээ зэрэг үндсэн шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэн иж бүрэн байдлаар гүйцэтгэв.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Эрүүл мэндийн байгууллагын 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг бодитой тодорхойлон, илэрсэн сул талыг арилгах, сайжруулахад чиглэсэн тодорхой санал, зөвлөмж боловсруулах, улмаар байгууллагын үйл ажиллагаагаар дамжин иргэдэд хүрэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээ

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах 5 чиглэлийн хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

1. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт;
2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт;
3. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт;
4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт;
5. Хэрэглэгчийн үнэлгээ.

3.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн дундаж хэрэгжилт 87.7 хувьтай байна.

Гүйцэтгэлийн ерөнхий дүнгээр төлөвлөгөөний хэрэгжилт хангалттай түвшинд байгаа боловч зарим зорилт, арга хэмжээний хэрэгжилт удаашралтай, төлөвлөсөн үр дүнд хараахан бүрэн хүрээгүй байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй нь төлөвлөлт бодит хэрэгцээ, боломж, нөөц, чадавхид суурилагагүй, санхүүжилт болон хүний нөөц дутмаг, бэлтгэл ажлыг бүрэн хангалгүй төлөвлөсөн, мөн хэрэгжилтэд тавих явцын хяналт, дэмжлэг сул байсантай холбоотой гэж дүгнэв.

Цаашид гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа салбарын бодит хэрэгцээ, эрсдэл, хүний нөөц, санхүүгийн боломжтой уялдуулан төлөвлөх, хэрэгжилтийн явцад тогтмол хяналт-шинжилгээ хийж, эрсдэлийг эрт илрүүлэн засах, шаардлагатай санхүүжилт, тоног төхөөрөмж, хүний нөөцийн дэмжлэгийг үе шаттай шийдвэрлэж ажиллах шаардлагатай.

3.2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2025 оны биелэлт дунджаар 79.0 хувьтай байгаа ба төлөвлөсөн зорилтод бүрэн хүрээгүй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс үзэхэд гадаад сургалтын хамрагдалт хангалтгүй (3.0 хувь), албан хаагчдын шилжилт хөдөлгөөн өндөр (21.3 хувь) байна.

Түүнчлэн Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.3 дахь заалтын дагуу тайлан, мэдээллийг хавсралт хүснэгт 3.6-д заасан хэлбэрээр бүрэн гаргаж ирүүлээгүй.

Цаашид хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор сургалтын тэнцвэртэй байдлыг хангах, гадаад сургалтын боломжийг нэмэгдүүлэх, хүний нөөцийн тогтвор суурьшлыг сайжруулах, мөн тайлан, мэдээллийг батлагдсан аргачлалын дагуу бүрэн, үнэн зөв боловсруулах, тайлагналын сахилга батыг сайжруулах шаардлагатай байна.

3.3. Нээлттэй мэдээллийн ил тод байдал

Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны харьяа Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас 2025 оны жилийн эцсийн байдлаар хийж, нийт үнэлгээг 94.0 хувьтай гэж дүгнэсэн нь байгууллагын мэдээллийн ил тод байдал өндөр түвшинд хүрснийг илэрхийлж байна.

Үзүүлэлт тус бүрээр авч үзвэл:

- Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 95.0 хувьтай;

- Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал 97.0 хувьтай;

- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 90.0 хувьтай;

- Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 100.0 хувьтай;

- Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал 100.0 хувьтай байна.

Үзүүлэлтүүдийн дүнгээс харахад байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээ болон бусад мэдээллийн ил тод байдал бүрэн хангагдсан түвшинд хүрч, мэдээллийн нээлттэй байдлын тогтолцоо төлөвшсөн, хэрэгжилт тогтвортой байна. Харин төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод байдал 90.0 хувьтай байгаа нь нийт үнэлгээнд бага зэрэг нөлөөлсөн хэдий ч ерөнхийдөө шаардлагын түвшинг өндөр хэмжээнд хангаж байна.

Иймд байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт нь нийт дүнгээрээ өндөр түвшинд хүрч, цаашид тогтвортой хадгалах болон зарим чиглэлд нарийвчилсан сайжруулалт хийх шаардлагатай гэж дүгнэв.

3.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үнэлгээний дүн 47.2 хувьтай үнэлэгдсэн бөгөөд өмнөх оны түвшнээс сайжраагүй, зорилтот түвшинд хүрээгүй, мөн аймгуудын дунджаас доогуур дараах үзүүлэлтүүд байна. Үүнд:

1. Өрх, сумын эрүүл мэндийн төвийн нийт үзлэгт гэрийн эргэлтийн эзлэх хувь;
2. В гепатитийн вакцины хамрагдалт (24 цаг);
3. Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь;
4. 28-36 долоо хоногтой төрсөн дутуу нярайн тоо;
5. Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд);
6. Нялхсын эндэгдлийн түвшин (1 000 амьд төрөлт тутамд);
7. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1 000 амьд төрөлт тутамд);
8. Амьгүй төрөлтийн түвшин, 1000 төрөлтөд;
9. Үр хөндөлтийн түвшин (15-49 насны 1000 эмэгтэйд);

10. Ходоодны шархлаа өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд);

11. Даралт ихсэх өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд);

12. Цөсний чулуу, цөсний үрэвслийн шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд);

13. Тархинд цус харвалтын нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд);

14. Зүрхний шигдээсийн нас баралтын түвшин (0-74 насны 10 000 хүн амд);

15. Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин (10 000 хүн амд);

16. Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин (10 000 хүн амд);

17. Эмчилгээнд орсон халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөнөөс эмчилгээний төгсгөлд эдгэрсэн хувь.

Дээрх үзүүлэлтүүдээс харахад анхан шатны тусламж, үйлчилгээний хүртээмж болон урьдчилан сэргийлэх ажлын гүйцэтгэл сул байгаагийн зэрэгцээ эх, хүүхдийн эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүд хангалтгүй түвшинд байна. Мөн халдварт бус өвчний хүндрэл, зүрх судасны өвчлөл, осол гэмтэл болон амиа хорлолтын нас баралтын түвшин өндөр хэвээр байгаа нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ хангалтгүй байгааг илтгэж байна.

Иймд анхан шатны тусламж үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх, эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, хяналт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх, мөн осол гэмтэл болон сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр цогц арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг зөвхөн эмнэлгийн тусламжийн гүйцэтгэлээр бус, харин урьдчилан сэргийлэх, эх, хүүхдийн эрүүл мэнд, халдварт бус өвчний менежмент болон гадны шалтгаант нас баралтын бууруулах цогц арга хэмжээний үр нөлөөгөөр харах ёстой.

Чанарын үзүүлэлтийн үнэлгээний дүнгээс дүгнэхэд салбарын гүйцэтгэлд “урьдчилан сэргийлэх чиг баримжаа сул, эмнэлзүйн тусламжийн хариу арга хэмжээ давамгай” хэвээр байна. Ялангуяа эрсдэлт бүлгийн дунд зохион байгуулах идэвхтэй илрүүлэг, тасралтгүй хяналт, лавлагаа шатлалын уялдаа, яаралтай тусламжийн

бэлэн байдал зэрэг хүчин зүйлсийг зэрэг сайжруулахгүйгээр үзүүлэлт богино хугацаанд мэдэгдэхүйц өөрчлөгдөх боломж хомс юм.

Дээрх бодлогын зөвлөмжийн хүрээнд чиглэсэн арга хэмжээг үе шаттай, тогтвортой хэрэгжүүлснээр эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэлтийн хамралт нэмэгдэж, эх хүүхдийн эндэгдэл болон халдварт бус өвчний шалтгаант нас баралт буурах, улмаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн үзүүлэлтүүд бодитоор сайжрах эерэг үр нөлөө гарах боломжтой.

3.5. Хэрэглэгчийн үнэлгээ

2025 оны жилийн эцсийн байдлаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ дунджаар 92.0 хувь буюу 4.6 оноогоор үнэлэгдсэн байна. Үнэлгээнд амбулаториор үйлчлүүлсэн болон хэвтэн эмчлүүлсэн нийт хэрэглэгчдээс түүвэрлэн сонгосон 11,447 иргэн хамрагдсан байна.

Үнэлгээний ерөнхий дүнгээр хэрэглэгчийн сэтгэл ханамж хангалттай түвшинд байгаа боловч тусламж, үйлчилгээтэй холбоотой зарим асуудал илэрсэн байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд, амбулаторийн үйлчилгээний хүртээмж, зохион байгуулалттай холбоотой асуудлууд зонхилж байна. Тухайлбал, амбулаторийн үзлэгийн цаг товлолын хүлээгдэлтэй гэж 17.0 хувь нь, товлогдсон цаг өнгөрснөөс хойш 30 минутаас дээш хугацаагаар хүлээсэн гэж үйлчлүүлэгчдийн 28.3 хувь нь хариулсан байна. Мөн эм, тариа, ороох, боох хэрэглэгдэхүүний хангалт муу байгаа талаар судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 33.0 хувь нь эмчийн санал болгосноор, 8.0 хувь нь өөрсдөө гаднаас худалдан авч хэрэглэсэн гэж хариулсан байна.

Дээрхээс дүгнэхэд, хэрэглэгчийн сэтгэл ханамж хангалттай түвшинд байгаа ч ялангуяа амбулаторийн үйлчилгээний зохион байгуулалт, хүлээгдэл, эмийн хангалттай холбоотой асуудлууд тулгамдсан хэвээр байна.

Дөрөв. Цаашид анхаарах асуудал, зөвлөмж

Байгууллагын 2025 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд илэрсэн тогтолцооны болон гүйцэтгэлийн доголдлыг арилгах, үйл ажиллагааны үр нөлөө, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

1. Байгууллагын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог үр дүнд суурилсан менежментийн зарчимд нийцүүлэн боловсронгуй болгож, шийдвэр гаргалтын ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах, нэгж хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх.

2. Гүйцэтгэлийн төлөвлөлтийг батлагдсан аргачлалын дагуу боловсруулж, суурь түвшин, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тоон болон чанарын хувьд хэмжигдэхүйц, бодитой, харьцуулах боломжтой байдлаар тодорхойлж, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналын уялдаа холбоог бүрэн хангах.

3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтэд тулгуурлан үнэлж, нотлох баримтад суурилсан, нэг мөр аргачлалтай, давхардалгүй, үнэн зөв тайлагнах тогтолцоог төлөвшүүлэх.

4. Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын хэрэгжилтийг бүрэн хангаж, төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, тайлагналын бүх үе шатанд арга зүйн нэгдмэл байдлыг мөрдөж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавих.

5. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг бодит үр дүнд чиглүүлэн сайжруулах, мөн албан хаагчдыг урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулах ажлыг тогтмолжуулах, албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг

6. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмуудын хэрэгжилтийг хангаж, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, судалгаа, шинжилгээний мэдээллийг бүрэн, тогтмол, хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар нийтэлж, мэдээллийн ил тод байдлыг бодитоор нэмэгдүүлэх.

7. “Төрийн байгууллагын цахим хуудсанд тавигдах шаардлага MNS 6285:2017” стандартыг мөрдөж, цахим хуудсыг стандартын дагуу шинэчлэн хөгжүүлж, мэдээллийн бүтэц, хүртээмж, хэрэглэгчдэд ойлгомжтой байдлыг сайжруулах.

8. Цахим хуудсын мэдээлэл байршуулах, шинэчлэх, хяналт тавих үйл ажиллагааг дотоод журмаар зохицуулж, мэдээллийн баяжилт, шинэчлэлийг тогтмол хийж, үнэн зөв, бүрэн, цаг үеэ олсон мэдээллийг нийтлэх дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх.

9. Байгууллагын санхүүгийн сахилга батыг сайжруулах зорилгоор өр, авлагын үүсэлтийг бууруулах, тэдгээрийг хугацаанд нь барагдуулах, мөн санхүүгийн урсгалд тогтмол хяналт тавих дотоод хяналтын механизмыг бэхжүүлэх.

10. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтүүдийн бууралтын шалтгааныг нарийвчлан тодорхойлж, сайжруулах арга хэмжээг зорилт болгон хэрэгжүүлэх, чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх.

11. Чанарын үзүүлэлтийг тайлагнахдаа нотолгоонд суурилсан, нэг мөр аргачлал ашиглаж, үзүүлэлт тус бүрийн өөрчлөлтийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийг тогтмол шинжилж, хяналт тавих.

12. Хүн/Үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, харилцааны соёлыг сайжруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны хамрагдалтыг нэмэгдүүлж, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох, тогтолцоог төлөвшүүлэх.

Тав. Нэгдсэн үнэлгээ

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн нэгдсэн үнэлгээний дүнгээр нийт гүйцэтгэлийн хувь 76.1 хувьтай үнэлэгдсэн бөгөөд үнэлгээг байгууллагын үндсэн таван чиглэлийн үзүүлэлтэд тулгуурлан тооцсон болно. Үүнд: i) Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 87.7 хувь, ii) Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилт 79.0 хувь, iii) Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үзүүлэлт 94.0 хувь, iv) Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт 47.2 хувь, v) Хэрэглэгчийн үнэлгээ 92.0 хувь тус тус үнэлэгдсэн бөгөөд жингийн коэффициентээр жигнэн тооцоход нийт нэгдсэн үнэлгээ 76.1 хувь байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт (47.2%) нь нийт нэгдсэн үнэлгээг бууруулахад голлох нөлөө үзүүлсэн байна.

Иймд цаашид i) Гүйцэтгэлийн төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналын уялдаа холбоог үр дүнд суурилсан менежментийн зарчимд бүрэн нийцүүлэх; ii) Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт, үнэлгээний тогтолцоог сайжруулах; чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх; iii) Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт, тайлагналтыг сайжруулах; iv) Хэрэглэгч төвтэй үйлчилгээний менежментийг бэхжүүлж, үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх зэрэг цогц арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Нэгдсэн үнэлгээний задаргааг дараагийн хуудсанд байрших Хүснэгт 1-т үзүүлэв.

**Хүснэгт 1. 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн
нэгдсэн үнэлгээний задаргаа**

№	Үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь	Жин	Оноо
1	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	87.7	0.2	17.5
2	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	79.0	0.15	11.9
3	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт	94.0	0.15	14.1
4	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт	47.2	0.3	14.2
5	Хэрэглэгчийн үнэлгээ	92.0	0.2	18.4
Нэгдсэн үнэлгээний хувь (жигнэсэн дүн)		76.1		

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
2026 оны 05 дугаар сар